

## ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

Нийслэлийн Засаг даргын санаачилгаар, Австралийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Стэнфордын Их сургуулийн Зөвлөлдөх Ардчилал төв, Азийн сан хамтран “Иргэдийн оролцоо-Хотын маргааш” Зөвлөлдөх санал асуулгыг өнгөрсөн оны 12 дугаар сард зохион байгуулсан юм.

**Хэн оролцсон бэ?** Шинжлэх ухааны үндэслэлтэй санамсаргүй түүврийн аргаар сонгогдон, уригдсан иргэд 2015 оны 12-р сарын 12,13-ны хоёр өдрийн турш Төрийн Ордонд зөвлөлдсөн. Энэхүү Зөвлөлдөх санал асуулгад оролцсон 317 иргэн хүн ам зүй болон хэлэлцэх асуудалд хандаж байгаа хандлагын хувьд нийслэлийн хүн амыг сайн төлөөлж чадсан юм. Учир нь тэдгээр 317 оролцогчдын хүн ам зүй болон хандлагыг Зөвлөлдөх санал асуулгын өмнө явуулсан судалгаанд оролцсон 1185 иргэдийнхтэй харьцуулахад ялгаа бараг гараагүй болно. Улаанбаатар хотын оршин суугчдын бичил нэгж нэг дор цугларан нийслэл хотод тулгамдаад байгаа зарим бэрхшээлүүдийн талаар хэлэлцэв. Судалгааны түүвэрлэлт хийх, судалгаа явуулах болон судалгаа авах судлаачдыг сонгон ажиллуулах ажлыг Эм Эм Си Жи зөвлөх компани гүйцэтгэсэн. Харин Зөвлөлдөх санал асуулгын жижиг бүлгийн хэлэлцүүлгүүдийг чиглүүлэх модератууруудыг Зориг сан зохион байгуулан ажилласан.

**Юу болсон бэ?** Улаанбаатар хотыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд тусгагдсан их хэмжээний зээл аван хэрэгжүүлэх 14 гол төслийг иргэдээр хэлэлцүүлэн эрэмблүүлэх зорилготой байсан. Хот их хэмжээний өр зээл тавихаасаа өмнө иргэддээ төслүүдийн талаар холбогдох мэдээллийг өгч улмаар мэдээлэл сайтай иргэдийн хувьд нэр бүхий 14 төсөл хэр чухал болохыг олж мэдэхийг зорисон юм.

Зөвлөлдөх санал асуулгын үеэр иргэдийн анхлан эрэмбэлсэн дараалал өөрчлөгдсөн. 14 төслийн 8 төслийн үнэлгээ мэдэгдэхүйц өөрчлөгдсөн бөгөөд үүнээс 3 төслийн үнэлгээ өсч 5 төслийн үнэлгээ буурсан байна. Зөвлөлдөх санал асуулгын бүх хэлэлцүүлгийн дараа оролцогч иргэд маань 3 асуудал дээр төвлөрч байв. Эхний асуудал нь байгаль орчинтой холбоотой байв. Эрэмбэлсэн дарааллаас харахад хамгийн их үнэлгээ авсан эхний 6 төслийн 4 нь байгаль орчинтой холбоотой төслүүд байсан бөгөөд цэвэр эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт болон хог хаягдалтай холбоотой асуудлуудыг тусгасан байсан. Сургууль цэцэрлэгийн барилгын дулаан техникийн шинэчлэлтийг хийх, Туул Сэлбэ голын орчныг сэргээн сайжруулах, Эко парк байгуулах болон Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулахыг иргэд хүссэн байна. Удаах асуудал нь үйлдвэрлэл болон хөдөлмөр эрхлэлтийн төвлөрлийг сааруулж хотын төвөөс гаргахад чиглэсэн төслүүд байсан. Иргэд Налайх дүүрэгт байгуулагдах барилгын материалын үйлдвэрлэл технологийн парк, Эмээлт орчим байгуулагдах хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк, Улаанбаатар хотын зүүн талд ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах төслүүдийг дэмжсэн. Түүнчлэн “аюултай ба хортой хог хаягдал гаргах болон хадгалах үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр компаниудыг хотын төвөөс нүүлгэн шилжүүлэх шаардлагатай” гэсэн санааг иргэд маш хүчтэй дэмжсэн байна. Сүүлийн асуудал нь өр, татвартай холбоотой байв. Метро (маш өндөр төсөвтэй) болон Экологийн коридор (орлогын эх үүсвэргүй) төслүүдийн үнэлгээ доошилсон явдлыг магадгүй дээрх гурван асуудалтай холбон үзэж болох байх.

**Иргэдэд ямар нөлөө үзүүлэв?** Оролцогч иргэдийн үр нөлөө, итгэл нэмэгдсэн. Тэдний “төрийн албан хаагчид над шиг хүмүүс ямар бодолтой байгааг тоодог анхаардаг” мөн “Улаанбаатар хотын захиргаа зөв зүйл хийж байгаа” гэсэн итгэл нэмэгдсэн. Үүнээс гадна Зөвлөлдөх санал асуулгын үйл явцыг бүхэлд нь өндрөөр үнэлсэн ба 95 хувь нь үйл явц болгон “ач холбогдолтой” байсан хэмээн үзжээ.

**Зөвлөх хороо.** Зөвлөлдөх санал асуулгын үйл явц бүхэлдээ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э. Бат-Үүл болон ноён Г. Занданшатар нараар удирдуулсан Зөвлөх хорооны хяналтан дор хэрэгжисэн. Зөвлөх хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд улс төр, бизнес, иргэний нийгмийн салбарын нэрт зүтгэлтнүүд багтсан болно. Зөвлөх хорооны гишүүд:

Ерөнхий сайд асан Д. Содном

Гадаад хэргийн сайд асан Ц.Гомбосүрэн

Хас банкны ТУЗ-ийн дарга Ч.Ганболд

Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн Философийн ухааны доктор, профессор Б.Даш-Ёндон

Гандантэгчинлэн хийдийн Хамба лам Д.Чойжамц

Монголын Урлагийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Т.Ариунаа

MCS группын Ерөнхийлөгч Ж.Од

Нийтлэлч Б.Батбаяр

Алтан тариа ХК-ийн захирал П.Цэнгүүн

Монфэмнэт Үндэсний сүлжээ ТББ-ын ахлах зөвлөх Д.Сүхжаргалмаа

МУИС-ийн Ректор Р.Бат-Эрдэнэ

**Дараагийн алхмууд.** Монголын анхны Зөвлөлдөх санал асуулга үр дүнтэй амжилттай болж өнгөрсөн тул хот 2 дахь Зөвлөлдөх санал асуулгыг Хотын дүрэм болон Улаанбаатар хотын өөрийн засаглалыг сайжруулах асуудлаар зохион байгуулахаар төлөвлөж байна.